

ОРОН НУТГИЙН СОНИН

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС | 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР



Өмнөговь аймаг, Ханбогд сум болон "Оюу толгой" ХХК-ийн

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

гарын үсэг зурах ёслол

Даланзадгад сумт
2015-04



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

"Оюу толгой" ХХК Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдтай 4 дүгээр сарын 22-нд Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа.

(2-р нүүрт)



**М.ГАНГАНЖАВ:БИДНИЙ
АЖЛЫН ҮР ДҮНД
АМЬТДЫН ӨСӨЛТ, ТОО
ХЭМЖЭЭ ЗӨВ ГАРНА**

Зэрлэг амьтны ангилалтад Ханбогд сумын 18 малчин оролцож байна
(6-р нүүрт)



**ГОВИЙН МАЛЧНААС
УУРХАЙН ОПЕРАТОР**

Жирийн малчнаас уурхайн оператор болсон нэгэн залуугийн тухай товч өгүүлвэ

(10-р нүүрт)



**ТОРОМНЫ НООСЫГ
САМНАЖ АШИГЛАХЫН
АЧ ТУС**

Торомны ноосыг хог хаягдалгүй, хялгас багатай авахын тулд самнах технологи ашиглах нь зүйтэй.

(13-р нүүрт)

“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИ, ӨМНӨГОВЬ АЙМАГ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



“Оюу толгой” ХХК Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдтай 4 дүгээр сарын 22-нд Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа.

Хамтын ажиллагааны гэрээ нь “Оюу толгой” ХХК орон нутгийн байгаль орчин, ус, уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежментийг сайжруулах, үндэсний түүх, соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлалыг

хөгжүүлэх, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрээс бараа үйлчилгээ худалдан авах зэрэг үндсэн чиглэлүүдээр дэмжлэг үзүүлэх, аймаг орон нутгийн зүгээс Оюу толгой төсөл, “Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахад цаашид талуудын баримтлах зарчим, нөхцөлийг тодорхойлсон баримт бичиг юм.

Гэрээний хүрээнд “Оюу толгой” ХХК “Хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан жил бүр 5

сая ам.долларын санхүүжилт хийх бөгөөд дээр дурдсан чиглэлүүдээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд уг хөрөнгийг зарцуулах юм. Аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх тухай шийдвэрийг компани, орон нутгийн төлөөллөөс бүрдсэн “Хөгжлийг дэмжих сан”-гийн удирдах зөвлөл гаргана.

Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ёслолын үеэр “Оюу толгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Эндрью Вүдлэй “Дөрвөн жил гаруй хугацаанд хэлэлцсэн энэхүү Хамтын ажиллагааны гэрээ нь бидний ажиллаж, амьдарч буй нутаг орны ард иргэд, засаг захиргаатай харилцан шүтэлцсэн хамтын ажиллагааг бүрдүүлэхэд чиглэсэн томоохон алхам боллоо.

Гэрээний дагуу өнөөдрийг хүртэл хийгдсэн ажлууд, тэр дундаа зам, эрчим хүч, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг гол чиглэлүүдээр олсон амжилтад үндэслэн цаашдын харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойллоо. Хамтын ажиллагааны гэрээ нь Өмнөговь аймгийн хөгжилд түлхэц өгөх нэг чухал хүчин зүйл болохын зэрэгцээ цаашид Монгол

Улсад хэрэгжих томоохон төслүүдэд жишиг болж чадна гэдэгт итгэлтэй байна” хэмээн онцлон тэмдэглэлээ. Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга Л.Батчулуун “Талууд орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. Энэ гэрээний дагуу Өмнөговь аймаг болон түншлэгч сумдын зүгээс “Оюу толгой” компанийн бизнесийн үйл ажиллагаанд бодитой дэмжлэг үзүүлэх, “Оюу толгой” компанийн зүгээс орон нутагт тулгарч байгаа асуудал, нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай зүйлсийн талаар нэгдсэн ойлголттой болж байгаа энэ

гэрээний давуу тал гэж ойлгож байна” гэв. Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа “Энэ гэрээ Өмнөговь аймгийн хөгжил цэцэглэлт, өмнөговьчуудын сайн сайхан амьдрал дэвжин дээшилэхийн үүдийг нээлээ” гэсэн бол Ханбогд сумын Засаг дарга Т.Буян-Өлзий “Хамтын ажиллагааны гэрээ нь хүн төвтэй оюуны хөрөнгө оруулалт болоод бүтээн байгуулалтын асар олон зүйлийг хийхээр төлөвлөсөн” гэж хэллээ.

Гэрээнд амжилттай гарын үсэг зурсанд баяр хүргэж хэлсэн үгэндээ УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ “Хамтын ажиллагааны гэрээ зурагдсан нь тус аймаг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг бодлогоор дэмжсэн

жишиг болж буйг харуулж байна” гэсэн юм. Хамтын ажиллагааны гэрээг Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон “Оюу толгой”-н Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу байгуулсан юм.

Нөгөөтэйгүүр, “Оюу толгой” ХХК нь Хамтын ажиллагааны гэрээг өөрийн үйл ажиллагааны нэг гол бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж, орон нутгийн тогтвортой хөгжлийг ханган, ирээдүй хойч үедээ зориулан эрүүл мэнд, боловсрол, ажлын байр, үнэ цэнэ бий болгоход өөрийн хувь нэмрийг оруулахыг чухалчилж байна.



СУРАГЧИД БАТЛАМЖАА ГАРДЛАА



“Оюу толгой” компанийн “Залуусын хөгжлийн хөтөлбөр” 2014-2015 оны хичээлийн жилд Өмнөговь аймгийн Даланзадгадад хэрэгжиж, Ерөнхий боловсролын 4 сургуулийн төгсөх ангийн 36 сурагч хамрагдсан байна. Эдгээр сурагчид 2015 оны 1 дүгээр сараас 3 сарын турш манлайллын болон хувь хүний төлөвшлийн чадамжуудын сургалтуудад хамрагдаж, 4 дүгээр сарын 20-нд батламжаа гардаж авлаа. Уг хөтөлбөрийн эхний шатны сургалтад хамрагдсан сурагчдаас шилдэг 5 сурагчийг шалгаруулж, “Оюу толгой” ХХК-иас

Өмнөговийн залууст зориулан хэрэгжүүлдэг Говийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах эрх олгоно. Эдгээр сурагчид нь их, дээд сургуульд суралцах хугацаандаа хөтөлбөрийн дараагийн шатны сургалтуудад Улаанбаатар хотод хамрах юм.

Оюутан байх хугацаандаа хөтөлбөрийн 5 шатанд бүрэн хамрагдсан залуучууд их, дээд сургуулиа төгсөөд нутагтаа ирж, Залуусын хөгжлийн хөтөлбөрийн сургагч багш болон дараа үеийн дүү нартаа сурсан мэдсэнээ

дамжуулах болно. Говь нутгийн сурагчид хөтөлбөрт хамрагдсандаа сэтгэл өндөр байсан бөгөөд төгсөлтийн арга хэмжээний үеэр өөрсдийн бэлтгэсэн урлагийн тоглолтоор зочдод бэлэг барилаа.

Төгсөлтийн үеэр аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Жамьянхорол “Улсын хөгжил хүнээс эхтэй байдаг. Хөдөө орон нутгийн залуусыг дэмжиж энэхүү хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь “Оюу толгой” компани нийгмийн хариуцлагаа ухамсарладаг, хариуцлага өндөртэй байгууллага болохыг илтгэж байна.

Өнөөдрийн энэ арга хэмжээ нь уг хөтөлбөр манай хүүхэд залууст хүрсэн, үр өгөөжтэй сургалт болсон гэдгийг илтгэж байна” гэж хэллээ.

Таван шаттай хөтөлбөр нь Монголын ирээдүй болсон хүүхэд, залуусыг ахлах ангиас нь эхлээд их, дээд сургуульд суралцах хугацаанд нь хөгжүүлж, ирээдүйн чадварлаг мэргэжилтэн, цаашлаад улс орны ирээдүйн манлайлагчдыг бэлтгэх зорилготой юм.

БАГШ, СУРАГЧИД МЭДЭЭЛЛИЙН ЭРИНТЭЙ ХӨЛ НИЙЛҮҮЛНЭ



“Оюу толгой” компанийн Мэдээллийн технологийн хэлтсийнхэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Ерөнхий боловсролын сургуулийн Мэдээлэл зүй болон багшийн хөгжлийн төвийг иж бүрэн тохижууллаа.

Үүгээр хоёр танхимын хооронд болон өрөөнүүд дотор дотоод сүлжээг “Оюу толгой” ХХК-ийн стандартын дагуу гүйцэтгэж, хоёр сүлжээний зогсуурыг шаардлагатай төхөөрөмжүүдийн хамт угсарч, нийт 45 ширхэг сүлжээний залгуур суурилуулсан байна. Эдгээр тоног төхөөрөмжийн нийт өртөг нь 15 орчим сая төгрөг болжээ.

Ингэснээр сумын сургуулийн багш, сурагчид мэдээллийн эринтэй хөл нийлүүлэн алхах өргөн боломж нээгдэж байгаа юм.

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК БОЛОН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИУДЫН МОНГОЛ АЖИЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ

/2015 оны 03 сарын 31-ний байдлаар/

Компаний нэр	Өмнөговь аймгийн харьяат ажилчдын тоо	Бусад	Нийт
1 “Оюу толгой” ХХК	387 15.9%	2044 84.1%	2431 100.0%
2 Туслан гүйцэтгэгч компаниуд	974 25.4%	2855 74.6%	3829 100.0%
Нийт дүн	1361 21.7%	4899 78.3%	6260 100.0%

№	Харьяалал	“Оюу Толгой” ХХК	Туслан гүйцэтгэгч компаниуд	Нийт
1	Өмнөговь	0	26	26
2	Өмнөговь/Баяндалай	6	4	10
3	Өмнөговь/Баян-Овоо	4	6	10
4	Өмнөговь/Булган	2	0	2
5	Өмнөговь/Даланзадгад	134	347	481
6	Өмнөговь/Гурвантэс	1	1	2
7	Өмнөговь/Ханбогд	216	487	703
8	Өмнөговь/Ханхонгор	0	8	8
9	Өмнөговь/Хүрмэн	2	2	4
10	Өмнөговь/Мандал-Овоо	1	3	4
11	Өмнөговь/Манлай	11	76	87
12	Өмнөговь/Номгон	2	3	5
13	Өмнөговь/Ноён	3	1	4
14	Өмнөговь/Сэврэй	3	1	4
15	Өмнөговь/Цогт-Овоо	0	1	1
16	Өмнөговь/Цогтцэций	2	8	10
Нийт		387	974	1361

М.ГАНГАНЖАВ: БИДНИЙ АЖЛЫН ҮР ДҮНД АМЬТДЫН ӨСӨЛТ, ТОО ХЭМЖЭЭ ЗӨВ ГАРНА

- Зэрлэг амьтны ажиглалтад Ханбогд сумын 18 малчин оролцож байна-



Өмнийн говьд өнтэй сайхан хавар болж байна. Ийм нэг өдөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн малчин М.Ганганжавын очлоо. Тэдний гадаах уяатай нялх ботгонууд мал төллөж байгааг сануулна. Тэрээр малаа маллахын зэрэгцээ зэрлэг амьтны ажиглалт, тооллогод оролцдог. “Оюу толгой” компани малчидтай хамтран Хамтын оролцоотой зэрлэг амьтны ажиглалт, тооллого хөтөлбөр хэрэгжүүлдэг. Дөрвөн цагийн улиралд байгаль дэлхий, ан амьтантай хамгийн ойр аж төрдөг хүмүүс бол малчид. Тиймээс малчидтай хамтран энэ хөтөлбөрийг 2010 оноос хэрэгжүүлэх болжээ. М.Ганганжавын хувьд 2012 оноос хөтөлбөрт хамрагдаж байгаа аж. Тэрээр “Бид нар хөтөлбөр хамрагдахын өмнө сургалтад суудаг. Бас Хустайн байгалийн цогцолборт газар, Их нарт байгалийн нөөц газарт очиж, сургалтад хамрагдаж, тэндхийн туршлагаас суралцсан. Өнөөдөр манай сумаас 18 малчин оролцож байгаагийн зургаа нь Номгон багийнх” хэмээн ярилаа.



хангадаг аж. Тэдний нутаг ерөнхийдөө нэлээд зэлүүд учраас нэг удаагийн явалтаар 54 км, отор нүүдлийн үедээ 70-90 км зайд ажиглалт, тооллого хийнэ. Тухайн үедээ таарсан амьтдын зургийг авч, тоолж, хэдэн цагт хаашаа явж байсан, хэдэн км-ийн зайд байсныг бичиж, тэмдэглэнэ. Сар бүрийн нэгэн, 15-нд хийх тооллого, ажиглалтаар хулан, зээр, үнэг, туулай, хярс гээд олон амьтан таардаг байна.

М.Ганганжав ажлынхаа талаар “Улирлын сүүлээр “Оюу толгой” компанийн энэ ажлыг хариуцсан хүн ирж тайлангаа авдаг. Бидний ажлын үр дүнд амьтдын өсөлт, тоо хэмжээ зөв гарна. Бас хулгайн ангаас сэргийлж байгаа. Сүүлийн үед хулгайн ан эрс багассан. Говьд байгалийн тэнцвэр алдагдахгүй байх нь хамгийн чухал” хэмээн тайлбарласан юм. Зэрлэг амьтан ажиглаж буй малчид өөр хоорондоо “Манай энд нэлээд хэдэн тооны хулан ирлээ. Танай тэнд хэр олон байна” хэмээн саналаа солилцох удаа ч цөөнгүй бий гэнэ. Байнга бэлчээрлэж, нүүдэллэдэг говийн амьтдын байршил олонтаа солигддог учраас ийнхүү мэдээллээ солилцдог аж.

“Оюу толгой” компани аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьдаг. Зөвхөн өөрийнхөө компанийн ажилтнууд биш хамтран ажилладаг бүх хүмүүс аюулгүй ажиллах шаардлага тавьдаг учраас идэвхтэн байгаль хамгаалагчид мотоциклээрээ 40-50 км/цаг хурдтай явахын зэрэгцээ оролцогч малчдыг эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалтанд хамруулж, эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэлээр хангасан байна.



Мөн түүнчлэн ажиглалт хийх үеийн хурдыг 40 км/цагаас илүүгүй байхыг байнга зөвлөдөг. Энэ бүхэн нэг талаас аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас ан амьтнаа үргээхгүй байх зорилготой. Түүнийг ажиглалт, тооллогоор явж байхад тэмээтэй цуг ус ууж байгаа хулан, ихэр янзагатай зээр зэрэг сонирхолтой зүйлс олон таарна. Тэр бүхнийг аль болох зургийн

хальсанд буулгахыг хичээдэг байна. Түүний тухай “Оюу толгой” ХХК-ийн орон нутгийн харилцааны ажилтан Н.Мөнхбаяр “Байгаль дэлхийг шинжиж, ажиглана гэдэг бол малчин түмний ахуй амьдралтай салшгүй холбоотой зүйл. Энэ ажиглалтыг шинжлэх ухааны судалгааны арга, аргачлалтай холбож малчин түмний мэдлэгээс хүртэх нь малчидтай хамтарсан зэрлэг амьтны ажиглалт, тооллогын нэг ач холбогдол юм.

М.Ганганжав бол 2012 онд зэрлэг амьтны ажиглалтыг малчидтай хамтарч хийсэн цагаас хойш идэвхтэй ажиллаж байгаа олон малчдын нэг. 2013 оны идэвхтэй сайн ажиглагчаар шалгарч, сонирхогчийн дурантай зургийн аппаратаар шагнуулсан. Бид малчдын байгаль ахуйтайгаа ойрхон амьдарлын хэв шинжийг сайн дурантай зургийн аппараттай хослуулснаар зэрлэг амьтадын тухай олон сонирхолтой зургийг цуглуулах боломжтой. Энэ бүхэн нь зөвхөн малчид төдийгүй Ханбогд сумын нийт зэрлэг амьтны талаарх мэдээллийн санг шинэчилж бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой” хэмээн ярилаа. Ханбогд сумын зэрлэг амьтны мэдээллийн санг баяжуулах, хулгайн ангаас сэргийлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтдыг хамгаалах энэ ажилд ийнхүү олон малчин сэтгэл зүтгэлээ зориулан оролцож байна. Тэдний хичээл зүтгэлээр их говийн чимэг болсон ан амьтад ч өсч үржих биз ээ.

ЭРДЭМТЭД ХАНБОГД СУМЫН СУРАГЧИДАЙ УУЛЗЛАА



“Оюу толгой” компаниас орон нутгийн соёлын өвийг хамгаалах, хадгалах зорилгоор хөтөлбөр хэрэгжүүлж, олон ажил хийж гүйцэтгэж байна. Үүний нэг нь Өмнөговь аймгийн Манлай сумын “Шар цав” дахь үлэг гүрвэлийн мөрийг авран хамгаалах ажил юм. Дэлхийд цөөхөн байдаг үлэг гүрвэлийн мөрийн эрдэм шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн Шинобу Ишигаки, Жеффри Ханату Алдшул нар Ханбогд сумын Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдтэй уулзаж археологи, палентологийн талаар сонирхолтой ариа өрнүүллээ. Сурагчид эрдэмтдээс мэргэжлээ хэрхэн сонгосон, хүн төрөлхтөн анх хэрхэн үүссэн зэрэг олон сонирхолтой асуултад хариулт авсан юм. Хоёр эрдэмтэн “Танайх шиг ийм соёлын ховор өвтэй нутаг дэлхийд цөөхөн. Нутаг усаа хайрлаарай” хэмээн хүүхдүүдэд захилаа.

Ц.ШАРХҮҮ: ХОЙЧ ҮЕДЭЭ ГАЗАР УСНЫ НЭР, БАЙРШЛЫГ ЗӨВ ТОГТООЖ ҮЛДЭЭХ ХЭРЭГТЭЙ



“Оюу толгой” компани үйл ажиллагаа явуулж байгаа Өмнөговь аймгийн Ханбогд сумын газар нутгийн нэрийг газрын зурагт буулгаж тэмдэглэлээ. Газар зүйн албан ёсны нэр ашигласан газрын зураг, газрын нэрийн санг бүрдүүлэх зорилгоор уг ажлыг гүйцэтгэжээ. Энэ ажилд “Оюу толгой” компаниас О.Батзориг, Д.Санжмятав, Т.Гантулга, Б.Мөнх-Эрдэнэ, Ханбогд شماас С.Адъяа, Г.Дүнжгэр, А.Мижиддорж, А.Цэцэг, Ц.Мижид, Ц.Шархүү, Д.Банди, Ю.Надмид нар оролцсон байна. Эдгээр хүмүүсийн нэг бол Ц.Шархүүтай ярилцлаа.

- **Та өөрийгөө манай уншигчид товч таницуулна уу?**
- Ханбогд сумын Номгон багийн иргэн Ц.Шархүү. Өндөр настны тэтгэвэрт гараад, одоо сумын төвдөө амьдарч байна.
- **Ханбогд сумын газар усны нэрийг газрын зурагт буулгаж, тэмдэглэх ажилд оролцсон тухайгаа ярих уу?**
- “Оюу толгой” компаниас санаачилж, орон нутгийн ахмадууд хамтран Ханбогд сумын газар усны нэрийг газрын зурагт буулгах, тэмдэглэх ажлыг 3 дугаар сарын 5-6-нд хийсэн. Үнэхээр цагаа олсон, чухал ажил боллоо. Сүүлийн үед хүүхэд, багачууд газар усаа мэдэхгүй, газар усаа хайрлаж, хамгаалахгүй байна. Газар усны нэр маш чухал. Ахмад буурлууд газар усандаа учир утгатай нэр өгч байсан түүхтэй. Хойч үедээ газар усны нэр, байршлыг зөв тогтоож үлдээх хэрэгтэй. Ялангуяа Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн газар нутагт. Энэ аймгуудад геологи, уул уурхайн олон байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

- **Та сумынхаа газар усны нэртэй холбоотой домог, түүхээс ярина уу?**
- Домог, түүх олон бий. Тухайлбал, Номгон багийн нутагт Даянчийн агуй байна. Дээр үед лам хүн даянч хийж, дотор нь гурван жил ном уншиж, суусан учраас ингэж нэрлэх болсон. Цэрэг явж байгаад дөрөөгөө гэсэн газрыг Дөрөөт улаан, баруун талд нь буунынхаа замгийг гэсэн тул Замаг улаан гэж нэрлэсэн түүхтэй. Төмөр замаас урагш байгаа цагаан уулыг цагаан ботго гэдэг. Ботгоны хэлбэртэй. Манай сумын Галбын уулыг 108 цагаан овоо, 108 булагтай гэж ярьдаг. Иймэрхүү домог, түүхтэй газар, усны нэрийг залуучуудад зааж өгч, нэрний холбогдлыг бичиж үлдээх хэрэгтэй.
- **Залуу хойч үедээ газар усныхаа нэрийг үнэн зөв үлдээх талаар ямар ажлууд хийвэл зүгээр вэ?**
- Залуучууд ялангуяа сургуулийн насны вхүүхдүүдэд газар ус, байгаль дэлхийгээ хамгаалах ардын уламжлалын талаар хичээл оруулах хэрэгтэй. Аялал зохион байгуулж, энэ газрын ингэж нэрлэдэг хэмээн зааж өгвөл хүүхдүүд байгаль, дэлхийгээ

хайрлаж, газар усны нэр, ус ургамлаа мэддэг болно. Одоо хэдхэн нэрээс бусдыг нь сайн мэдэхгүй байна. Манай сумын сургууль өндөр настан биднээр ахлах ангийнханд лекц, яриа хэлэлцүүлэг хийлгэвэл болно. Тэгвэл хүүхдүүд энэ овоо ийм нэртэй, манай сум ийм рашаан устай гэж мэдэж авна. Ханбогд сум олон рашаан устай. Сумын төвөөс баруун урагш 7 км зайд ходоодны Доржшүгийн рашаан бий. Бас Хаалгын рашаан байна. Дээхэн үед хангайгаас хоёр суга таягтай хүн ирж, нэг сар уугаад л таягаа орхиод явсан гэдэг. Мөн Морьтын хужир, Равжаа хутагтын гэрийн буурь, сумын төвийн зүүн урд байдаг хүн чулуугаа хүртэл хүүхдүүдэд үзүүлж, таниулах нь чухал.

- **Ундай голыг яагаад ингэж нэрлэх болсон юм бол?**
- Анх энэ голоос олон хүн ундаалдаг байсан учраас онд нь гол гэсэн нэр өгч. Сунжирсаар Ундай болсон гэдэг. Ундай голоос цангаага тайлсан гамин цэргүүд зүүн хөвөөгөөр нь явж, Жавхлант багаас урагш барьж явсан чулуугаа үлдээсэн учраас талын чулуу үүссэн түүх бий.



ЗАРЛАЛ

Цахилгаан хайчаар тэмээ ноослох ажлыг Ханбогд сумын “Баян саглар” болон “Говийн баян эрдэнэ” хоршоод зохион байгуулахаар төлөвлөж байна. Тэмээгээ ноослуулах хүсэлтэй малчид, иргэд эдгээр хоршоодын дарга нартай холбогдоно уу.

Харилцах утас: “Баян саглар” хоршоо - 88307227
 “Говийн баян эрдэнэ” хоршоо - 88207599, 99037599, 88707705

ГОВИЙН МАЛЧНААС УУРХАЙН ОПЕРАТОР



Өмнийн говьд өрнөж буй их бүтээн байгуулалт, Оюу толгойн уурхай орон нутгийн иргэдийн аж амьдралд ихээхэн өөрчлөлт авчирч, томоохон эргэлт хийж байна. Оюу толгойн уурхай үйл ажиллагаагаа явуулдаг Өмнөговь аймгийн Ханбогд суманд ямар их өөрчлөлт, хөгжил дэвшил авчирч байгааг бүхэлд нь тоочно гэвэл хэтэрхий нуршуу болно. Тиймээс энэ удаа жирийн малчнаас уурхайн оператор болсон нэгэн залуугийн тухай товч өгүүлбэр.

Ханбогд сумын иргэн Д.Хүрлээ Оюу толгойн ил уурхайд хүнд машин механизмын операторчоор ажилладаг. Тэрээр энэ сумын, Оюу толгойн уурхай оршдог Жавхлант багийн нутагт төрж, өссөн нэгэн. Аливаа шинэ содон зүйлд хүсч тэмүүлдэг нь залуу хүний араншин. Төрөлх суманд нь Оюу толгойн бүтээн байгуулалт өрнөж, дэлхийд тэргүүлэх том уурхайтай болсон цагаас тэнд ажиллах, хүдэр зөөдөг нүсэр том машиныг нь жолоодох хүсэл түүнд төржээ. Энэ сумын олон залууд

ийм гэгээн хүсэл мөрөөдөл төрсөн нь мэдээж. Амины хэдэн малаа адгуулан аж төрж байсан Д.Хүрлээ 2012 оны 7 дугаар сард “Оюу толгой” компанид зам арчилгааны ажилтнаар анх ажилд орж, хоёр жил орчим ажиллажээ. Дараа нь орон нутгийн хүмүүсийг хүнд даацын машины операторчийн мэргэжлээр сургаж, ил уурхайд ажиллуулна гэсэн зарын дагуу бүртгүүлжээ.

Эхлээд аюулгүй ажиллагааны сургалтад нэг сар орчим сууж, хүнд даацын машины загвар болох сургалтын симулятор дээр дадлага хийж. Үүний дараа хоёр сар орчим дагалдан жолоочоор ажиллажээ. Өмнө нь суудлын жижиг оврын автомашинтай байсан болохоор “Комацү 930E-4SE” машиныг анх жолоодоход үнэхээр аварга том мэт санагдаж байсан гэнэ. Ингээд сургагч багш нарт сурсан, мэдсэнээ шалгуулж, өнгөрсөн оны 8 дугаар сарын 1-нээс Оюу толгойн уурхай хэмээх их айлын ам бүлийн нэгэн гишүүн болжээ. Түүний жолооддог “Комацү 930E-4SE” хэмээх хүнд даацын машин 3500 морины хүчтэй, 15 метр өргөн, 18 метр урт, нэг удаа 290 тонн ачаа ачдаг. Шатахууны сав нь гэхэд л 4.5 тонны багтаамжтай. Үнэхээр аварга эд байгаа биз. Өнөөдөр ил уурхайд 28 ийм машин ажилладаг юм.

“Манайхан нэг гэр бүлийнхэн шиг эвтэй, гар нийлэн ажилладаг сайхан хамт олон. Бие биедээ байнга зөвлөнө, тусалж дэмжинэ. Хамт олондоо их баярлаж явдаг” хэмээн Д.Хүрлээ сэтгэл хангалуун ярьж байна. “Оператор үнэхээр сайхан мэргэжил. Аливаа уурхайд аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьдаг. Осол зөрчилгүй ажиллах л хамгийн чухал, хамгийн эрхэм зорилго” гэж нэмж хэлнэ билээ. Оператор гэдэг үгийг уул уурхайгаас хол хөндий зарим хүн сайн ойлгохгүй байж магадгүй. Хүнд даацын машины жолоочийн мэргэжлийн нэр л дээ.

“Сонирхсон мэргэжлээрээ төрсөн нутагтаа ажиллах үнэхээр сайхан шүү” гэж Д.Хүрлээ бахархангүй өгүүлсэн юм. Өсч төрсөн нутагтаа, дэлхийд тэргүүлэгч том уурхайд хамгийн сүүлийн үеийн хүчирхэг техникийн жолоо мушгих аз завшаан тохиосон нь залуу хүнд сайхан байлгүй яахав дээ.

Д.Хүрлээгийн жишээ бол хөдөө нутгийн малчин залуус эмээлт хүлгийн суран жолоог эрчит техникийн залуураар сольж, шинэ боломж, шинэ амьдрал өөд тэмүүлж байгаагийн бодит нотолгоо юм.

ТӨСЛИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА

Малын эрүүл мэндийг сайжруулах, улмаар хүн амыг малын гаралтай эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг мал эрүүлжүүлэх, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэлэг санал, санаачилга дэвшүүлсэн ТӨСЛИЙН САНАЛ ИРҮҮЛЭХИЙГ УРЬЖ БАЙНА.

ТӨСӨЛД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА

1. Орон нутгийн мал эмнэлэгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн, мал эрүүлжүүлэх, малын халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинэлэг, дэвшилтэт санал санаачилгыг дэвшүүлсэн байх
2. Төсөл нь хүрээлэн буй орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй байх
3. Төслийг санаачлагч, хэрэгжүүлэгч нь албан ёсны бүртгэлтэй хоршоо байх
4. Тухайн хоршоо нь мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий малын эмч, мэргэжилтэнтэй байх
5. Төслийн үр дүнд хоршоо нь цаашид бие даан тухайн чиглэлээр төрөлжиж, тогтвортой үйл ажиллагаа явуулах зорилгоо тодорхойлсон байх
6. Төслийн нийт санхүүжилтын 20-иос доошгүй хувийг хоршоо өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлэх

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. Хоршооны танилцуулга
2. Төслийн дэлгэрэнгүй танилцуулга, санхүүгийн тооцоо, задаргаа
3. Эрх бүхий байгууллагаас малын эмчид олгосон мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл

Төслийг Ханбогд сумын Мал эмнэлэг, үржлийн тасаг, зөвлөх баг, “Оюу толгой” ХХК-ийн холбогдох хэлтсийн төлөөлөл бүхий ажлын хэсэг дээрх мэдээлэлд тулгуурлан сонгон шалгаруулалт хийнэ.

Сонирхсон хоршоод төслийн санал, холбогдох материалаа 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 17.00 цагаас өмнө “Оюу толгой” ХХК-ийн Ханбогд сумын салбарт ирүүлнэ үү.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ЦАХИМААР БҮРТГЭНЭ

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс орон нутгийн иргэдэд Гадаадад зорчих эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг дараах байдлаар хүргэж байна.

Үүнд:

1. Гадаад паспорт шинээр захиалах хүсэлт хүлээн авч бүртгэх
 - 1 жилийн хүчинтэй гадаад паспорт 22500 төгрөг
 - 5 жилийн хүчинтэй гадаад паспорт 32500 төгрөг

Шинээр захиалсан гадаад паспорт 30 хоногийн дотор хэвлэгдэн ирнэ. Орон нутгаас гадаад паспорт захиалахад яаралтай үйлчилгээ байхгүй. Харин Улаанбаатар хотод УБЕГ-ын Иргэний бүртгэл, гадаад паспортын газарт биечлэн очиж захиалахад яаралтай үйлчилгээний хөлс 10000 төгрөг төлж, үйлчилгээг ажлын 3 өдөрт багтаан үзүүлнэ.

2. Гадаад паспортын хүчинтэй хугацааны сунгалтын бүртгэл
 - 1 жил 4500 төгрөг
 - 2 жил 6500 төгрөг
 - 3 жил 8500 төгрөг
 - 4 жил 10500 төгрөг
 - 5 жил 12500 төгрөг

Гадаад паспортын хүчинтэй хугацааны сунгалтын бүртгэлийг ажлын 3 өдөрт багтаан үйлчилнэ. Үйлчилгээний хөлс болон тэмдэгтийн хураамжинд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10.4.1, Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын хавсралтын 4.1, 4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3. Монгол-Хятадын хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхийг Өмнөговь аймгийн Ханбогд, Номгон, Баян-Овоо, Хүрмэн, Гурвантэс, Ноён, Баяндалай суманд оршин суух бүртгэлтэй иргэнд олгоно.
 - Нэг удаагийн үнэмлэх 3000 төгрөг
 - Олон удаагийн үнэмлэх 10000 төгрөг

Жич: Гадаадад зорчих эрхийн бүртгэлд хүсэлт гаргасан иргэн өөрийн биеэр ирж, хурууны хээгээр мэдээллээ уншуулж бүртгүүлнэ. Иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн болон хүчинтэй байдлыг алдагдуулсан бол өөрийн оршин суух хаягийн бүртгэлтэй сумын улсын бүртгэгчид хүсэлт гаргахаас гадна өөрт аль байгаа ТҮЦ(Төрийн үйлчилгээний цахим машин)-д хурууны хээгээр мэдээллээ уншуулж иргэний үнэмлэхээ дахин захиалах боломжтой. ТҮЦ машинд захиалсан иргэний үнэмлэхээ өөрийн оршин суух хаягийн бүртгэлтэй сумын улсын бүртгэгчээс авна. Иргэний үнэмлэхний үнэ 18500 төгрөг. 25, 45 насны сунгалт хийлгэхэд иргэн заавал өөрийн биеэр ирж мэдээллээ шинэчлэн бүртгүүлнэ. Хуулийн этгээдийн улсын бүртгэл 2015 оны 3 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн цахимаар бүртгэгдэж байгаа бөгөөд burtgel.mn хаягийн Цахим бүртгэл хэсэгт хандана.

Шаардлагатай мэдээлэл өгөх болон санал хүсэлт хүлээн авах утас: 70534288, 70534388, 70534588, 70534788
Цахим хаяг: www.ubh.om.gov.mn

ТОРОМНЫ НООСЫГ САМНАЖ АШИГЛАХЫН АЧ ТУС

Малчдад өгөх зөвлөгөө

Бэлчээрийн мал аж ахуйн чухал түүхий эдийн нэг нь ноос, ноолуур байдаг. Монгол ямааны ноолуур дэлхийд нэр хүндтэй түүхий эдийн нэг болсон ч ноолуураас их дутахааргүй чанартай сарлагийн хөөвөр, тэмээний эм ноос, торомны ноос зэргийг тусгайлан бэлтгэж, боловсруулж,

үлддэг учир ноолууран дахь хялгасны агууламж бага, үйлдвэрлэлийн гарц өндөр байдаг. Иймд торомны ноосыг хог хаягдалгүй, хялгас багатай авахын тулд самнах технологи ашиглах нь зүйтэй юм. Судалгааны үр дүнгээр нэг настай торомны самнасан дээжин дэх ноолуурын агууламж

ноосоор бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тэр нь хэрэглэгчдийн дунд эрэлт сайтай болсон байна. Үүнтэй холбоотой үйлдвэрлэгчид торомны нарийн, зөөлөн биений ноосыг тусгайлан авах сонирхолтой байдаг атал малчид “торомны ноос” гэсэн ганцхан стандартын доор торомныхоо эр, эм бүх ноосыг хольж бэлтгэдэг байв.

Хүснэгт 1 Тэмээ, торомны ноосны нэмэгдсэн өртгийн харьцуулсан судалгаа, төгрөг

Түүхий эд	1 кг ноос, ноолуурын үнэ	Зардал	Нэмэгдсэн өртөг	Эцсийн үнэ
Ямааны ноолуур	65000	35501	124499	225000
Тэмээний ноос	4500	21869	93631	120000
Торомны ноос	4500	22871	102629	130000

эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл ноос, ноолуурын зах зээлийг зохих хэмжээгээр өргөтгөх боломж бий. Өнгөрсөн жил тэмээ, торомны түүхий ноос кг нь 4500-5000 төгрөгөөр үнэлэгдэж байв. Торомны ноосыг тусад нь ялгаж аваад сүлжмэл бүтээгдэхүүн хийхэд нэг кг торомны ноосонд 22.871 төгрөгийн нэмэгдэл зардал гарч 130.000 төгрөгийн эцсийн бүтээгдэхүүн гарч байна.

хяргаснаас 2.8 хувиар илүү, хялгас, завсрын үсний агууламж 2.0 хувь, хогт хольц 0.8 хувиар бага байв. Иймд торомны ноосыг хог хаягдалгүй, хялгас багатай авахын тулд самнах технологи ашиглах хэрэгтэй. 2007 онд батлагдсан тэмээний ноосны бэлтгэлийн стандартаар (MNS 36:2007) тэмээний ноосыг эр ноос, эм ноос, торомны ноос гэсэн бүдүүн тойм 3 ангиллаар бэлтгэж байсан нь түүхий эд бэлтгэлийн чанартай уялдуулан зах зээлийн үнэ бүрдэх, урамшуулал тогтоох шаардлагыг хангаж чадахгүй байна. Үүний улмаас тэмээний ноос, түүний дотор ямааны ноолуураас дутахгүй чанартай торомны ноос үнэгүйдэж, малчдын орлогод муугаар нөлөөлж иржээ. Сүүлийн жилүүдэд зарим үйлдвэрүүд торомны

Олон улсын ноос, нэхмэлийн байгууллагаас ноосны чанарыг тодорхойлохдоо “Super S” ангиллыг ашигладаг. Торомны ноос SUPER 130s-150s ангилалд хамаарагдаж байгаа нь олон улсын зах зээлд илүү өндөрөөр үнэлэгдэх бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтойг харуулж байна. Ингэснээр тэмээний ноосны зах зээлд өндөр үнэлэмжтэй чанартай хэсгийг өндөр үнэ хүргэх, бэлтгэх арга технологид шинэчлэл хийх, түүхий эдийн чанарыг боловсруулах үйлдвэрийн технологийн шаардлагад нийцүүлэх гэсэн зорилтуудыг шийдэж байна.

ЭМЧ НАР АНГЛИ ХЭЛНИЙ МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЛЭЭ

Өмнөговь аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч нар англи хэлний сургалтаа амжилттай дүүргэж, гэрчилгээгээ гардлаа. Энэхүү сургалтыг Өмнөговь аймгийн Засаг дарга санаачилсан бөгөөд тус аймгийн Нэгдсэн эмнэлэг бүсийн оношлогоо, эмчилгээний төв болж өргөжсөн төдийгүй уул уурхай, аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа учраас эмч нарынхаа англи хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд ийнхүү анхаарсан байна. Гэрчилгээгээ авсан эмч нар болон сургалтыг санхүүжүүлсэн “Оюу толгой” компанид талархлаа илэрхийллээ. “Оюу толгой” компани нийгмийн хариуцлага, орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд энэ санаачилгыг дэмжин санхүүжүүлсэн юм. Уг сургалтыг Улаанбаатар хотын “Talk Talk English” гадаад хэлний сургалтын төвийн гадаад мэргэжилтэн удирдан явуулсан байна.




“ОЮУ ТОЛГОЙ”-Н ТОЙМ МЭДЭЭ

“Оюу толгой” компани үйл ажиллагаагаа аюул ослоос ангид тогтвортой явуулж, оролцогч талуудад үр өгөөжөө өгөх үүрэг хүлээсэн билээ. Бид энэ булангаар дамжуулан орон нутаг дахь худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөрөнгө оруулалт зэрэг үндсэн чиглэлээр олж буй ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хүргэх болно.

Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт


(сая ам.доллар - сараар)



2015 оны эхний гурван сарын байдлаар Өмнөговь аймагт бүртгэлтэй 50 гаруй ханган нийлүүлэгч “Оюу толгой”-д бараа, үйлчилгээ нийлүүлээ.

Татвар, хураамж, бусад төлбөр

(сая ам.доллар - сараар)



“Оюу толгой” компани нь 2010-2014 онд төлсөн татварын дүнгээрээ улсын хэмжээнд эхний хоёрт жагссан талаар Татварын ерөнхий газар мэдэгдсэн.

* 2015 оны I улирлын өсөн нэмэгдсэн дүнд 15 сая ам.долларын татварын урьдчилгаа төлбөрийн суутган тооцоо багтсан болно.

Орон нутгаас ирсэн санал, хүсэлт, гомдол


2015 оны 4-р сар (Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сум)

Санал: Дөрөвдүгээр сард орон нутгаас нийтдээ дөрвөн (4) санал хүлээн авсан бөгөөд эдгээрийн гурав (3) нь талархал илэрхийлсэн, нэг (1) нь хамтран ажиллах ажлын талаарх санал байлаа.

Гомдол: Орон нутгаас хүний нөөцтэй холбоотой нэг гомдол хүлээн авсан ба үүнийг хүний нөөцийн хэлтсийн хариуцах албан тушаалтанд хүргэж, шийдвэрлүүлэн хариу өгөхөөр ажиллаж байна.

Хүсэлт: Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нийтдээ арван дөрвөн (14) хүсэлт ирсэн бөгөөд үүнээс дэмжлэг туслалцаа, хандив хүссэн хүсэлт найм (8), бүтээн байгуулалт/гэрээтүүдтэй холбоотой гурав (3), бусад асуудлаар хоёр (2), аюулгүй байдалтай холбоотой төрлөөр нэг (1) хүсэлт тус тус хүлээн авлаа. Эдгээрээс хандив туслалцаа хүссэн зургаа (6), бусад гэсэн төрлийн нэг (1) хүсэлтийг холбогдох хэлтэс албан тушаалтнуудад дамжуулан шийдвэрлэхээр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Бусад долоон (7) хүсэлтийг шийдвэрлэж хариуг хүргэлээ.

Орон нутгаас хүлээн авсан хүсэлт
2015 оны 4-р сар



- Хандив тусламж
- Бүтээн байгуулалтын төсөл/гэрээтүүд
- Бусад
- Аюулгүй байдал

“Оюу толгой” компанитай холбоотой асуудлаар otcommunities@ot.mn хаягаар эсвэл 9903 4732 (Оюу толгой уурхай), 9509 0391 (Ханбогд сумын оффис), 9909 8406 (Даланзадгад сумын оффис) руу холбогдоно уу. Гомдлын маягтыг дээрх оффисуудаас авч болно.

ОРОН НУТГИЙН СОНИН

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС

Редактор Ч.Батпүрэв
Мэдээллийг бэлтгэсэн: Д.Билгүүн,
Ж.Мөнгөндолгоо, Б.Болормаа, О.Батзориг

Гэрэл зургийг: А.Хатан-Оол,
Б.Идэрбаатар

Зохион байгуулагч: Л.Янжинлхам

Та бүхэн “Орон нутгийн сонин”-той холбоотой санал хүсэлтээ Улаанбаатар хот болон Ханбогд сум дахь Орон нутгийн харилцааны ажилтнаар дамжуулан бидэнд илгээгээрэй.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мөнхис Цамхаг, 1 давхар, Утас: 976-11-331880, Факс: 976-11-331885

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Цагаан булагийн 8-р баг.
“Оюу толгой” ХХК-ийн Өмнөговь дахь Төлөөлөгчийн газар
Утас: 976-7053-3961, 976-7053-3963
Факс: 976-11-331890

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Техникийн сургалтын төв.
“Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн салбар
Утас: 976-331880 (5316)
976-153512188

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ot.mn цахим хуудаснаас авна уу.